

Улирлын урьдчилсан төлөв

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Цаг агаар, Орчны, Тоон загварчлал, Судалгааны Хэлтэс (ЦАОТЗСХ)-ээс 2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 01 дүгээр саруудын цаг агаарын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг агаар \(weather.gov.mn\)](http://weather.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.


Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ЦАОТЗСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ


2.1 11–01 дүгээр саруудын уур амьсгал

Сарын дундаж агаарын температур арваннэгдүгээр сард Баян–Өлгий, Завхан, Хөвсгөл, Архангай, Булганы ихэнх, Увс, Ховдын зарим газар, Төв, Сэлэнгийн зүүн, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтийн хойд хэсгээр -12...-18°C, Хөвсгөлийн баруун хойд хэсгээр -18...-22°C, Говь – Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговийн өмнөд, Дорнодын зүүн хэсгээр -2...-8°C, бусад нутгаар -8...-12°C хүйтэн байдаг (**Зураг 1а**).




Зураг 1а. 11 дүгээр сарын агаарын температурын ОЖД (1991-2020)

Арванхоёрдугаар сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр $-24\ldots-30^{\circ}\text{C}$, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр $-10\ldots-16^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-16\ldots-24^{\circ}\text{C}$ хүйтэн байдаг (**Зураг 3а**).




Зураг 3а. 12 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)

Нэгдүгээр сард Баян–Өлгийн нутаг, Увсын хойд болон өмнөд, Завхан, Хөвсгөл, Сэлэнгийн ихэнх, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр $-26\ldots-32^{\circ}\text{C}$, Говь–Алтай, Баянхонгор, Дорноговийн өмнөд, Өмнөговийн ихэнх нутгаар $-12\ldots-18^{\circ}\text{C}$, бусад нутгаар $-18\ldots-26^{\circ}\text{C}$ (**Зураг 5а**) хүйтэн байдаг.




Зураг 5а. 2026 оны 01 дүгээр сарын агаарын температурын ОЖД (1991-2020)

Хур тунадасны хувьд арваннэгдүгээр сард Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 4–8 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–4 мм (**Зураг 2а**).




Зураг 2а. 11 дүгээр сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

Арванхоёрдугаар сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 2–8 мм, бусад нутгаар 0–2 мм (**Зураг 4а**).



Зураг 4а. 12 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)


Нэгдүгээр сард Хангайн нурууны төгсгөл, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дорнодын тал нутгаар 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм (**Зураг 5а**) ордог байна.



Зураг 6а. 2026 оны 01 дүгээр сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

Гурав. 2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРААС 2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРУУДЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


Арваннэгдүгээр сард. Агаарын дундаж температур Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн нутаг, Завханы зүүн, Баянхонгор, Өвөрхангайн хойд, Төвийн баруун хэсгээр ОЖД–аас хүйтэн, Дорнодын нутаг, Хэнтийн зүүн, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 16**).



Зураг 16. 11 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

**[Х–агаарын температур ОЖД–аас хүйтэн,
Д–агаарын температур ОЖД–аас дулаан,
Н–агаарын температур ОЖД–ын орчим]**

Сарын нийлбэр хур тунадас Өмнөговийн зүүн, Дорноговийн өмнөд хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 26**).




Зураг 26. 11 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Б–хур тунадас ОЖД–аас бага,

Н–хур тунадас ОЖД-ийн орчим]

Арванхоёрдугаар сард. Агаарын дундаж температур Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Төвийн нутаг, Увс, Завханы зүүн, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн хойд, Хэнтийн баруун хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 36**).




Зураг 36. 12 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[X–агаарын температур ОЖД–аас хүйтэн,

H–агаарын температур ОЖД–ын орчим]

Сарын нийлбэр хур тунадас Сэлэнгэ, Хэнтий, Дорнодын нутаг, Булган, Төвийн зүүн хойд, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД–аас ахиу, Өмнөговийн зүүн өмнөд, Дорноговийн өмнөд хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 66**).




Зураг 46. 12 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[И–хур тунадас ОЖД–аас ахиу,

Б–хур тунадас ОЖД–аас бага,

Н–хур тунадас ОЖД-ийн орчим]


Нэгдүгээр сард. 2026 оны 1 дүгээр сарын агаарын дундаж температур Увс, Завханы нутаг, Баян–Өлгий, Ховд, Говь–Алтайн хойд, Баянхонгорын баруун хойд, Хөвсгөл, Архангайн баруун хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6а**).



Зураг 56. 2026 оны 01 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

**[X–агаарын температур ОЖД–аас хүйтэн,
H–агаарын температур ОЖД–ын орчим]**

2026 оны 1 дүгээр сарын нийлбэр хур тунадас Баян–Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг, Ховд, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангайн хойд, Дундговийн баруун хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй байна (**Зураг 66**).



Зураг 66. 2026 оны 01 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[И–хур тунадас ОЖД–аас ахиу,

Н–хур тунадас ОЖД–ийн орчим]

3.2 Зөвлөмж

2025 оны 11 дүгээр сард Хэнтийн зүүн хойд, Дорнод аймгийн нутгаар ОЖД–аас дулаан байх бол, төвийн аймгуудын нутгаар 11 болон 12 дугаар саруудад ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байна. Харин 2026 оны 01 дүгээр сарын хувьд нутгийн баруун хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байна.

Хур тунадасны хувьд говийн зүүн өмнөд хэсгээр 2025 оны 11 болон 12 дугаар саруудад ОЖД–аас бага байх бол 2025 оны 12 дугаар сард нутгийн зүүн хойд хэсгээр, 2026 оны 01 дүгээр сард нутгийн төв болон баруун хэсгээр тус тус ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.